

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНД ҮНДЭСЛЭСЭН ЗӨВЛӨМЖ

2023 оны 02 сарын 14-ний өдөр

Сайншанд сум

Нэг. Зорилго

Монгол Улсын Засгийн газрын болон орон нутгийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн биелэлтийг хангуулахад дэмжлэг үзүүлж, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах чадварыг нэмэгдүүлэхэд энэхүү зөвлөмжийн зорилго оршино.

Хоёр. Боловсруулсан арга зүй

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагууд, сумдын Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхээр зөвлөмж боловсруулав.

Гурав. Зөвлөмж

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн нэгдсэн үнэлгээгээр **90.9% “A”** дүгнэгдсэн.

Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай зөвлөмжийг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

1. Бодлогын баримт бичгийн хүрээнд:

- Урт хугацааны бодлогын баримт болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнаадаа урьд онтой харьцуулж өссөн дүнгээр, үр дүнг тайлагнаж хэвших;
- Бодлогын баримт бичгийг шалгуур үзүүлэлт, суурь түвшин хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнах;
- Тайлан бичихдээ мэдээ, мэдээлэл төлөвлөгөөний хэлбэрээр бичихгүй байх;
- Товч тодорхой хэмжигдэхүйц, үр дүнд суурилсан байх;
- Товчилсон нэр томьёо ашиглахгүй, Монгол хэлний зөв бичиг, найруулга, хэл зүйн дүрмийг баримтлах зэрэг болно.

2. Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд:

- Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэхдээ тухайн жилд хэрэгжүүлэх төлөвлөгөөг нарийвчлан гаргаж гүйцэтгэн үр дүнг тусган тайлагнах;
- Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, заавар, стандартыг мөрдлөө болгон албан хаагчдыг тасралтгүй сургаж, мэргэшүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллуулан үр дүн гаргахад анхаарах;
- Аймгийн Засаг дарга болон холбогдох дээд шатны байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг бүртгэн хэрэгжилтийг заасан цаг хугацаанд гүйцэтгэх;
- Аливаа арга хэмжээг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор бодит үр дүнг тайландаа дурдах;

- Сайншанд, Замын-Үүд сумдын суурьшлын бүсэд хот хөгжлийн хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулж, дахин төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлэх;
- Төрх гэр бүлийн худалдан авах чадварт нийцүүлэн орон сууцжуулах бодлого хэрэгжүүлэх;
- Цагаан сувартгын зэс молибдений үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхэд орон нутгаас ус ашиглуулах гэрээ байгуулах, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох, замын трасс батлах зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах;
- Газар зүйн нэрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан байгуулах зэрэг болно.

3. Байгууллагын ил тод байдлын хүрээнд:

- Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээллийг ил тод мэдээлэх;
- Хэрэглэгчээс сэтгэл ханамжийн судалгааг авсны дараа заавал судалгааны үр дүнг гаргах, мэдээлэх;
- Зарим үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлэн ажилласан байгаа хэдий ч хуульд заасны дагуу ил тод байдлыг хангах, иргэдийг мэдээллээр хангах зэрэг болно.

Зөвлөмжөөр өгөгдсөн ажил арга хэмжээг хяналтад авч, эрчимжүүлэн ажиллаж, хэрэгжилтийг 2023 оны 06 сарын 25-ны дотор ирүүлэхийг мэдэгдэж байна.

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Н.ХОНГОРЗУЛ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА



Ш.АЛИМАА

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.Баттуяа

А.БАТТУЯА